

**ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ,  
АШИГЛАХ ҮЕД МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ  
ХАНГАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү шаардлагын зорилго нь хүний хувийн мэдээлэл /цаашид “мэдээлэл” гэх/-ийг цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангахад тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлно.

1.2.Хүний хувийн мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулж, боловсруулж, ашиглахад Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, олон улсын стандартын байгууллагаас баталсан ISO/IEC 27001, ISO/IEC 27701 стандарт, Монгол Улсын стандарт “Теле хяналтын системийн ерөнхий шаардлага MNS 6423:2019”-д нийцсэн байна.

**Хоёр. Хамрах хүрээ**

2.1.Энэхүү шаардлагыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага дагаж мөрдөнө.

2.2.Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад энэ журам хамаарахгүй.

**Гурав. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах  
үйл ажиллагааны зарчим**

3.1.Мэдээлэл хариуцагч болон мэдээлэл боловсруулагч нь мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглахдаа Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан зарчмаас гадна дараах зарчмыг баримтална.

- 3.1.1.хууль ёсны, шударга, ил тод байх;
- 3.1.2.ашиглах зорилго тодорхой байх;
- 3.1.3.мэдээллийн эзэн нэвтрэх боломжтой байх;

**Дөрөв. Үйл ажиллагааны зохион байгуулалтад тавигдах шаардлага**

4.1.Мэдээлэл хариуцагч болон мэдээлэл боловсруулагч нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах албан тушаалтнуудын үүрэг хариуцлага, эрх мэдлийг хуваарилсан байна.

4.2.Мэдээллийг зориулалтаар нь ангилж, нууцлалын түвшин тогтоон, хандах эрхийг тодорхойлж, зохих түвшний хамгаалалтаар ханган, хандалт бүрт тэмдэглэгээ хийдэг байна. Үүнд нийтэд зориулсан мэдээлэл хамаарахгүй.

4.3.Мэдээллийн аюулгүй байдлыг үр дүнтэй нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах, тасралтгүй сайжруулахад шаардагдах нөөцүүдийг тодорхойлсон байна.

4.4.Мэдээллийг зөвшөөрөлгүй, хууль бусаар задруулах, дамжуулах, боловсруулах, хадгалах, санамсаргүй байдлаар алдах, устгах, өөрчлөхөөс урьдчилан сэргийлэх физик болон кибер түвшний хамгаалалтыг тогтоосон байна.

4.5.Болзошгүй аюул заналаас мэдээллийг хамгаалах зорилгоор эрсдэлийг тогтоох, үнэлэх, дүгнэх, тайлагнах, эрсдэлийг бууруулах, хяналт тавих арга техникийг боловсруулж, баталсан байна.

4.6.Мэдээллийн системийг зохисгүй ашиглах, түүнээс үүдэн хортой программд өртөх, систем болон сүлжээний гэмтэл учруулах, хууль эрх зүйн асуудалд орох эрсдэлүүдээс урьдчилан сэргийлсэн бодлого, зөвлөмжтэй байна.

4.7.Үйл ажиллагаандаа мэдээллийн аюулгүй байдлын шаардлагуудыг нэгтгэн, шаардлагатай нөөцүүдийг хүртээмжтэй байлгана.

4.8.Мэдээлэл боловсруулалтын аюулгүй байдлыг хангах техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээний үр нөлөөг тогтмол туршиж, үнэлдэг байна.

#### **Тав. Мэдээллийн системийн аюулгүй байдалд тавигдах шаардлага**

5.1.Мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад хэрэглэгдэх мэдээллийн систем нь дараах шаардлагыг хангасан байна.

5.1.1.мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд нууцлал болон хандах эрхийн түвшин тогтоож, тогтмол шинэчилдэг байх;

5.1.2.мэдээллийг нууцлах, шифрлэх техникийн боломжийг бүрдүүлсэн байх;

5.1.3.хортой кодоос хамгаалах программ хангамж ашиглах;

5.1.4.мэдээллийн системүүд дээрх үйл явдал, хэвийн бус онцгой зүйл, аюулгүй байдалтай холбоотой үйлдлүүд болон систем администратор, сүлжээний инженерүүдийн үйлдлийг бүртгэж, хадгалдаг байх;

5.1.5.үйл ажиллагааны өөрчлөлтийг бүртгэдэг, өмнөх хувилбаруудыг шаардлагатай үед буцаан сэргээдэг, хандалтуудыг хянах боломжтой байх;

5.1.6.мэдээлэл боловсруулах хэрэгслүүдийн бодит цагийг стандарт цагийн системтэй синхрон ажиллуулдаг байх;

5.1.7.мэдээллийн системийг хөгжүүлэх, өргөтгөх, шинэчлэх боломжтой байх;

5.1.8.үйлдлийн систем, сүлжээ, программуудад өөрчлөлт орох бүрт техникийн эмзэг байдлын үнэлгээ хийх;

5.1.9.мэдээлэл боловсруулах хэрэгслийн орчны аюулгүй байдлыг хангах;

5.1.10.зохиогчийн эрхийн зөрчилгүй программ хангамж ашиглах;

5.2.Мэдээлэл тээгч, боловсруулах техник хэрэгслүүдэд зөвшөөрөлгүйгээр хандах эрсдэлийг бууруулахын тулд “цэвэр ширээ”, “цэвэр дэлгэц”-ийн бодлогыг хэрэгжүүлнэ.

5.3.Хортой кодоос хамгаалах арга хэрэгслийн талаар албан хаагч бүр зохих түвшний мэдлэгтэй байна.

### **Зургаа. Хадгалах технологид тавигдах шаардлага**

6.1.Мэдээлэл хариуцагч нь мэдээллийг хадгалах дараах шаардлагуудыг хангасан байна.

6.1.1.мэдээлэл хадгалах тусгай тоног төхөөрөмжтэй, хандах эрхийн зохицуулалттай, лог бүртгэлийн сервертэй, орчны аюулаас хамгаалагдсан байх;

6.1.2.халдлага болон хортой кодоос хамгаалагдсан байх;

6.1.3.мэдээлэл нөөцлөх /backups/ боломжтой байна. Мэдээллийн хуулбарыг нөөцөлж, нөөцийг тогтмол шалгах;

6.1.4.хадгалагдсан мэдээллийг зөвшөөрөлгүй унших, засварлах, хуулбарлах, устгахаас урьдчилан сэргийлэх;

6.1.5.хадгалах хэрэгсэл дэх баталгаажуулалт мэдээллийг задруулах, засварлах, устгах, мэдээлэл нэмэхээс урьдчилан сэргийлэх;

6.1.6.зайнаас идэвхгүй болгох, устгах, түгжих (lockout) боломжтой байх;

6.1.7.хадгалах төхөөрөмжид хандах эрхтэй хэрэглэгчийн ашиглаж байгаа программ болон техник хангамжийн суурилуулалт, түүний шинэчлэл, сүлжээнд холбох ажиллагааг тусгайлан тогтоох ;

6.1.8.хэрэглэгч мэдээллээ баталгаажуулсны дараа тухайн мэдээллийг хадгалдаг байх;

6.1.9.хэрэглэгч өөрийн мэдээлэлдээ хэзээ, хаанаас хандсаныг нь хадгалдаг байх;

6.1.10.мэдээллийг дамжуулах, хадгалах, зөөвөрлөх явцад зөвшөөрөлгүйгээр өгөгдлийг унших, хуулах, устгах боломжгүйг баталгаажуулах;

## **Долоо. Хяналт**

7.1.Хүний эрхийн Үндэсний комисс нь мэргэжлийн байгууллагатай хамтран Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 22.5, 22.6, 23.2 болон энэхүү шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

7.2.Хүний эрхийн Үндэсний комисс нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 22.6, 23.2 болон энэхүү шаардлагыг зөрчсөн талаар гомдол ирсэн, хяналт мониторингийн дүнгээр зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох мэдээллийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллын дагуу эрх бүхий байгууллагад шилжүүлж, холбогдох арга хэмжээг авна.

7.3.Хүний эрхийн Үндэсний комисс нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон энэхүү шаардлагын хүрээнд хийсэн хяналтын дүн, мэдээ, хяналт тавьж ажилласан тайланг олон нийтэд мэдээлж ажиллана.